



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/11/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	14
3.5.5 Үндсэн хөрөнгө	14
3.5.6 Өр төлбөр	15
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Харьяа байгууллагууд.....	19
4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	19
4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа	19
4.2.2 Албан шаардлага	19
4.2.3 Зөвлөмж.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	24
5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТБӨЯХ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их хурал
УҮГ	Улсын үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.ЗАЯАБАЛ ТАНАА

2022.03.25 № 07/702
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Татварын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,113,161.3	4,221,416.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	882,214.4	460,165.8
33	АВЛАГА	933,543.6	1,470,182.9
34	УРЬДЧИЛГАА	10,000.0	2,523.5
35	БАРАА МАТЕРИАЛ	2,287,403.3	2,288,544.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,175,692.5	61,856,547.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,175,692.5	61,856,547.0
39200	Биет хөрөнгө	41,832,877.5	46,564,248.9
39300	Биет бус хөрөнгө	3,342,814.9	15,292,298.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	49,288,853.8	66,077,963.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,579.3	680,041.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,579.3	680,041.5
41300	Өглөг	11,624.0	485,773.7
41400	Урьдчилж орсон орлого	18,955.4	194,267.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,258,274.4	65,397,922.2
51	Засгийн газрын хувь оролцоо	49,258,274.4	65,397,922.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	20,015,564.2	20,015,564.2
51200	Хуримтлагдсан үр дүн	25,085,966.6	41,225,774.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,156,743.6	4,156,583.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	49,288,853.8	66,077,963.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	75,555,940.0	78,253,111.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,991,544.7	19,331,949.2
120	Нийтлэг татварын бус орлого	28,991,544.7	19,331,949.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,564,395.3	58,921,161.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	50,289,622.7	60,886,422.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,289,622.7	60,886,422.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,137,656.2	51,532,261.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,390,208.2	28,901,438.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,372,544.4	3,763,182.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,511,154.7	1,593,769.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,883,309.9	1,767,660.4
2105	Нормативт зардал	42,509.9	160,310.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	295,380.5	392,864.2
2107	Томилолт, зочны зардал	166,832.9	189,372.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,636,548.5	6,166,278.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,839,167.2	8,597,384.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,151,966.5	9,354,161.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	25,266,317.3	17,366,688.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,168,434.5	1,025,185.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	24,097,882.9	16,341,502.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,497,023.4	-	26,497,023.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,338,246.6	-	-1,338,246.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,158,776.8	-	25,158,776.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,614.7	-	1,614.7
5	Тайлант үеийн үр дүн	24,097,882.9	-	24,097,882.9
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	49,258,274.4	-	49,258,274.4
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-201,855.0	-	-201,855.0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,056,419.4	-	49,056,419.4
9	Тайлант үеийн үр дүн	16,341,502.8	-	16,341,502.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,397,922.2	-	65,397,922.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	333,543,491.1	276,506,923.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,825,030.6	5,055,582.1
120	Нийтлэг татварын бус орлого	6,825,030.6	5,055,582.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,718,460.4	271,451,341.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,878,064.6	262,651,389.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,878,064.6	262,651,389.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,233,530.5	44,431,084.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,364,433.4	28,817,057.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,349,773.5	3,827,942.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,511,493.0	1,607,793.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,484,092.8	1,461,262.5
2105	Нормативт зардал	295,526.4	717,959.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	333,928.4	328,624.8
2107	Томилолт, зочны зардал	154,011.5	152,641.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,990,885.6	6,207,585.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	749,385.9	1,310,218.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,644,534.2	218,220,305.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,665,426.4	13,855,534.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,821,161.2	14,277,582.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,821,161.2	14,277,582.6
2200	Дотоод эх үүсвэрээр	5,821,161.2	14,277,582.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,821,161.2	-14,277,582.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	844,265.3	-422,048.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,949.2	882,214.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	882,214.4	460,165.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,718,137,700.00	56,868,794,822.25	2,849,342,877.75	95.2
УРСГАЛ ЗАРДАЛ	46,757,637,700.00	44,446,423,525.25	2,311,214,174.75	95.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,831,327,000.00	42,520,135,730.25	2,311,191,269.75	94.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,631,372,600.00	28,696,862,499.40	1,934,510,100.60	93.7
Үндсэн цалин	17,139,093,100.00	16,588,354,185.63	550,738,914.37	96.8
Нэмэгдэл	5,706,173,400.00	5,824,774,892.19	-118,601,492.19	102.1
Унаа хоолны хөнгөлөлт	3,349,808,000.00	2,862,100,145.92	487,707,854.08	85.4
Урамшуулал	4,436,298,100.00	3,421,633,275.66	1,014,664,824.34	77.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,147,384,800.00	3,817,916,984.26	329,467,815.74	92.1
Тэтгэврийн даатгал	2,918,434,300.00	2,688,248,087.21	230,186,212.79	92.1
Тэтгэмжийн даатгал	307,237,500.00	288,639,012.72	18,598,487.28	93.9
ҮОМШӨ-ний даатгал	245,790,100.00	227,811,343.67	17,978,756.33	92.7
Ажилгүйдлийн даатгал	61,447,700.00	58,434,084.75	3,013,615.25	95.1
Эрүүл мэндийн даатгал	614,475,200.00	554,784,455.91	59,690,744.09	90.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,617,139,400.00	1,597,377,118.74	19,762,281.26	98.8
Гэрэл, цахилгаан	204,010,500.00	201,669,658.81	2,340,841.19	98.9
Түлш, халаалт	633,626,200.00	619,049,571.10	14,576,628.90	97.7
Цэвэр, бохир ус	80,446,300.00	77,721,789.83	2,724,510.17	96.6
Байрны түрээс	699,056,400.00	698,936,099.00	120,301.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	1,249,749,700.00	1,239,144,806.14	10,604,893.86	99.2
Бичиг хэрэг	285,585,900.00	284,882,684.07	703,215.93	99.8
Тээвэр, шатахуун	170,924,200.00	171,232,007.37	-307,807.37	100.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	309,056,200.00	297,919,658.70	11,136,541.30	96.4
Ном, хэвлэл	22,076,800.00	20,978,734.00	1,098,066.00	95.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	37,105,200.00	36,036,098.00	1,069,102.00	97.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	425,001,400.00	428,095,624.00	-3,094,224.00	100.7
Нормативт зардал	234,000,000.00	234,000,000.00	-	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	232,000,000.00	232,000,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	275,263,600.00	272,396,370.00	2,867,230.00	99.0
Багаж, техник, хэрэгсэл	113,318,200.00	110,584,529.00	2,733,671.00	97.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,301,300.00	11,219,627.00	81,673.00	99.3
Урсгал засвар	150,644,100.00	150,592,214.00	51,886.00	100.0
Томилолт, зочны зардал	150,186,200.00	148,339,601.00	1,846,599.00	98.8
Дотоод албан томилолт	110,645,800.00	108,809,600.00	1,836,200.00	98.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	39,540,400.00	39,530,001.00	10,399.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,234,059,200.00	6,224,266,694.83	9,792,505.17	99.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,636,369,300.00	1,631,178,684.31	5,190,615.69	99.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,624,600.00	7,048,420.00	576,180.00	92.4
Даатгалын үйлчилгээ	30,196,200.00	30,014,308.80	181,891.20	99.4
Тээврийн хэрэгслийн татвар	5,944,800.00	5,049,886.00	894,914.00	84.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,271,100.00	1,522,000.00	749,100.00	67.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,219,232,700.00	1,217,725,800.72	1,506,899.28	99.9
Газрын төлбөр	5,383,400.00	4,690,495.00	692,905.00	87.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,327,037,100.00	3,327,037,100.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	292,171,500.00	289,831,655.88	2,339,844.12	99.2
Бараа үйлчилгээний бусад зардал	62,210,000.00	62,209,307.00	693.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	229,961,500.00	227,622,348.88	2,339,151.12	99.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,926,310,700.00	1,926,287,795.00	22,905.00	100.0

Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бусад урсгал шилжүүлэг	1,926,310,700.00	1,926,287,795.00	22,905.00	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	510,433,900.00	510,433,450.00	450.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,217,917,900.00	1,217,895,870.00	22,030.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	197,958,900.00	197,958,475.00	425.00	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,960,500,000.00	12,422,371,297.00	538,128,703.00	95.8
Барилга байгууламж	12,460,500,000.00	11,957,428,812.00	503,071,188.00	96.0
Их засвар	500,000,000.00	464,942,485.00	35,057,515.00	93.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,718,137,700.00	56,868,794,822.25	2,849,342,877.75	95.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,708,137,700.00	53,858,794,822.25	2,849,342,877.75	95.0
Улсын төсвөөс санхүүжих	56,708,137,700.00	53,858,794,822.25	2,849,342,877.75	95.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,010,000,000.00	3,010,000,000.00	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,890,000,000.00	3,009,862,900.00	-119,862,900.00	104.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	137,100.00	119,862,900.00	0.1
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,768	3,676	-92	97.6
БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	-	100.0
Төсвийн байгууллага	33	33	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,884	1,838	-46	97.6
Удирдах ажилтан	55	55	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,616	1,570	-46	97.2
Үйлчлэх ажилтан	213	213	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,884	1,838	-46	97.6
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,485	1,485	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	399	353	-46	88.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,129,281,037.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,089,604,237.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,794,250,300.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		120,195,015.00
210101	Үндсэн цалин		120,195,015.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		10,025,022.97
210201	Тэтгэврийн даатгал		10,025,022.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		17,716,276.00
210304	Байрны түрээс		17,716,276.00
2104	Хангамж, бараа материалын зардал		236,120,545.48
210401	Бичиг хэрэг		63,889,449.00
210402	Тээвэр, шатахуун		73,520,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		29,071,251.48
210404	Ном, хэвлэл		10,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,936,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		57,403,845.00
2105	Нормативт зардал		483,959,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		483,959,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		281,602,296.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		58,650,000.00
210602	Тавилга		166,145,272.00
210604	Урсгал засвар		56,807,024.00
2107	Томилолт, зочны зардал		4,302,000.00
210702	Дотоод албан томилолт		4,302,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		452,811,886.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		443,423,946.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,387,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		187,517,909.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		88,855,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		98,661,929.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,295,353,937.19
2132	Бусад урсгал шилжүүлэг		166,981,635.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		165,906,635.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,128,372,302.19
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		150.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		636,077.55
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,127,736,074.64
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		39,676,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		39,676,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		39,676,800.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,129,280,887.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,129,280,887.64
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		963,187,781.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		198,541,270.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,967,551,836.16
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-150.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		150.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг мөрдөж, шагнал урамшууллыг илүү олгохгүй байх, олон автомашинтай аймаг, нийслэлийн Татварын хэлтсүүдийн автомашиныг цэгцлэх, албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтнуудын автомашин ашиглах асуудлыг таслан зогсоох, аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулж дотоод хяналтыг сайжруулах, нягтлан бодогчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хооронд ахлах аудитор П.Чанцалдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/515 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны зорилго нь Татвар төлөгч хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино. Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.
- Мэдээллийн технологид суурилсан "Цахим татварын алба" болох.
- Төрийн захиргааны удирдлагаар хангах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай 190 дүгээр тушаал;
- ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- ЗГ-ын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-нд баталж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Татварын ерөнхий газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар нь 2021 онд 5 зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газраас тайлант онд харьяа татварын хэлтсүүд болон Татварын ерөнхий газар, Том татвар төлөгчийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсээс Татварын ерөнхий газрын 2021 оны үйл ажиллагаанд шалгалт хийсэн боловч шалгалтын тайлан эцэслэн ирээгүй тул танилцаж чадаагүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 49,385.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 740.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Татварын ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,789.1 сая төгрөгөөр буюу 1.3 дахин нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 460.1 сая төгрөг болж, өмнөх оноос 422.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	1.7	1.7	-
Банканд байгаа бэлэн мөнгө	882,212.7	460,164.1	(422,048.6)
Дүн	882,214.4	460,165.8	(422,048.6)

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 331.2 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 128.9 сая төгрөг ахмадын сангийн дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй 48.8 сая төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан, И-баримтгүй болон анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 147.2 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- И-баримтгүй болон зөрүүтэй дүнтэй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан. /Говь-Алтай 45.3 сая, Сэлэнгэ 33.5 сая, Хөвсгөл 4.6 сая, Говь-сүмбэр аймаг 0.8 сая, Хан-Уул 13.8 сая, Сонгино хайрхан 5.2, Налайх 1.8 сая, Баянзүрх 1.2 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Говь-Алтай аймаг 3.9 сая, Баянгол 24.1 сая, Налайх 5.5 сая, Багануур 4.0 сая, Сүхбаатар дүүрэг 3.5 сая төгрөг/;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй, үр ашиггүй зарцуулалт гаргасан. /Төв 13.3 сая, Дундговь 2.8 сая, Говь-Алтай аймаг 1.0 сая, Чингэлтэй 13.3 сая, Баянзүрх 8.7 сая, Баянгол 6.9 сая, Нийслэл 2.8 сая төгрөг/

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,470.2 сая төгрөг болж, өмнөх оноос 536.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	351.3	3,956.0	3,604.7
Татаас, санхүүжилтийн авлага	199,314.8	1,118,303.8	918,989.0
Байгууллагаас авах авлага	730,017.6	345,217.1	(384,800.5)
Хувь хүмүүсээс авах авлага	3,859.9	2,706.0	(1,153.9)
Дүн	933,543.6	1,470,182.9	536,639.3

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өссөн нь төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос Сангийн сайдын 2021 оны 217 дугаар тушаалаар давсан орлогыг зарцуулах эрх олгож, 709.4 сая төгрөгийг Төрийн санд татан төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 15.8 сая төгрөгийн дараах авлага байна. Тухайлбал:

- Дампуурсан арилжааны банкнуудтай холбоотой 11.9 сая төгрөгийн авлага. /Нийслэл Сэргээн босголт банк 9.8 сая, Сонгинохайрхан Сэргээн босголт банк 0.7 сая, Хөвсгөл аймаг Сэргээн босголт банк 1.4 сая төгрөг/;
- Нийслэлийн татварын газрын хувь хүнээс авах ХХОАТ-ын авлага 1.2 сая төгрөг
- Ажлаас чөлөөлөгдсөн ажилчидтай холбоотой 2.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. /Нийслэл 0.5 сая, Баянзүрх дүүрэг 2.2 сая төгрөг/

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2.5 сая төгрөг болж, өмнөх оноос 7.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	10,000.0	2,523.5	(7,476.5)
Дүн	10,000.0	2,523.5	(7,476.5)

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Завхан аймгийн Татварын хэлтсийн 2.2 сая төгрөгийн шатахууны төлбөр, Багахангай дүүргийн Татварын хэлтсийн 0.3 сая төгрөгийн гаржийн түрээсийн төлбөрийн урьдчилгаа байна.

Өмнөх оны үлдэгдлээс Том татвар төлөгчийн газар ажилчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж 10.0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлд үндэслэн зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 2,288.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	9.7	24.4	14.7
Эм боох	1,591.7	14,495.3	12,903.6
Бэлэн бүтээгдэхүүн	55,316.1	32,331.0	(22,985.1)
Бичиг хэргийн материал	484,857.6	541,156.0	56,298.4
Аж ахуйн материал	668,502.7	653,867.2	(14,635.5)
Сэлбэг хэрэгсэл	29,740.3	10,762.3	(18,978.0)
Түлш, шатах тослох материал	22,537.7	55,968.2	33,430.5
Барилгын засварын материал	71,959.6	28,607.8	(43,351.8)
Хүнсний материал	4,400.0	5,404.5	1,004.5
Бусад хангамжийн материал	943,058.9	941,084.8	(1,974.1)
Мал амьтад	5,429.0	4,843.0	(586.0)
Дүн	2,287,403.3	2,288,544.5	1,141.2

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн эм боох материал 12.9 сая төгрөг, бичиг хэргийн материал 56.3 сая төгрөг, түлш, шатах тослох материал 33.4 сая төгрөгөөр худалдан авснаас голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт: Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн, бараа материалыг шууд зардалд бүртгэсэн, их хэмжээгээр нөөцөлсөн, ашиглагдахгүй бараа материалын үлдэгдэлтэй зэрэг нийт 77.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд: /Увс 7.1 сая, Говьсүмбэр аймаг 3.5 сая, Сонгинохайрхан 35.6 сая, Хан-Уул 25.5 сая, Багануур дүүрэг 5.4 сая төгрөг/

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 82,412.1 сая төгрөг болж, өмнөх оноос 22,592.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	51,082,744.2	60,648,220.7	9,565,476.5
Барилга, байгууламж, орон сууц	18,000,804.6	18,526,090.1	525,285.5
Авто-тээврийн хэрэгсэл	3,641,303.6	3,684,393.6	43,090.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	23,678,828.3	23,660,281.9	(18,546.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,021,624.9	3,185,568.8	163,943.9
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	125.9	125.9	-
Бусад үндсэн хөрөнгө	359,395.5	396,666.7	37,271.2
Дуусаагүй барилга байгууламж	2,375,400.0	11,189,832.3	8,814,432.3
Ном	5,261.4	5,261.4	-
Биет бус хөрөнгө	8,737,250.6	21,763,851.5	13,026,600.9
Программ хангамж	4,640,522.8	4,477,184.9	(163,337.9)
Бусад биет бус хөрөнгө	4,096,727.8	17,286,666.6	13,189,938.8
Дүн	59,819,994.8	82,412,072.2	22,592,077.4

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 9,855.3 сая, урсгал зардлын төсвөөс бэлтгэсэн 23.1 сая, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 14,538.4 сая, дээд шатны болон бусад байгууллагаас балансаас баланст шилжүүлэн авсан 699.2 сая, үндсэн үйл ажиллагааны болон давсан орлогоос бэлтгэсэн 203.7 сая, бусад эх үүсвэрээс 433.1 сая, нийт

25,752.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр балансаас баланст шилжүүлсэн 2,173.3 сая, акталсан 987.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга байгууламж данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн Хөвсгөл, Увс, Баянхонгор аймгуудын татварын хэлтсүүдийн барилгын ажил дуусаж, улсын комисс хүлээн авсан боловч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр гараагүйгээс 11,189.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт: Хөрөнгө дутагдсан, орлогод аваагүй, жилийн эцсийн тооллогын тооцоо бодсон акт, илтгэх хуудас нь эд хариуцагч нарын картын дүнгээс зөрүүтэй, үлдэх өртөггүй болсон хөрөнгийг данс бүртгэлээс хасаж шийдвэрлээгүй, дахин үнэлж бүртгээгүй зэрэг нийт 223.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд: /Дорноговь 54.5 сая, Төв аймаг 39.0 сая, Нийслэл 128.2 сая, Багануур дүүрэг 1.3 сая төгрөг/

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 680.0 сая төгрөг болж, өмнөх оноос 649.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	4,247.9	976.2	(3,271.7)
Байгууллагад төлөх өглөг	6,065.3	484,797.4	478,732.1
Татварын өглөг	773.5	-	(773.5)
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	537.2	-	(537.2)
Бусад урьдчилж орсон орлого	18,955.4	194,267.9	175,312.5
Дүн	30,579.3	680,041.5	649,462.2

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 483.0 сая төгрөгийн барилгын барьцаа, 194.3 сая төгрөгийн орлогын албан татварын тэмдэгтийн төлбөр, 2.7 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг байна.

Нийт өр төлбөрөөс 6.0 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч нь байхгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 65,397.9 сая төгрөг болж, өмнөх оноос 16,139.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	20,015,564.2	20,015,564.2	-
Хуримтлагдсан үр дүн	25,085,966.6	41,225,774.3	16,139,807.7
Өмнөх үеийн үр дүн	988,083.7	24,884,271.5	23,896,187.8
Тайлант үеийн үр дүн	24,097,882.9	16,341,502.8	(7,756,380.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,156,743.6	4,156,583.7	(159.9)
Дүн	49,258,274.4	65,397,922.2	16,139,647.8

Эх сурвалж: Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 16,341.5 сая төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд тайлант онд хөрөнгө акталж устгаснаас үүссэн дахин үнэлгээний зөрүү 0.1 сая, шүүхийн шийдвэр, Сангийн яамны Төрийн сангийн газрын 2021 оны 12-1/6397 дугаар албан бичгээр тооцоо нийлж, 9.3 сая төгрөгийн авлага хаасан, өмнөх онд тавилга худалдан авахаар байгуулсан гэрээт ажил хэрэгжих

боломжгүй болсон тул 192.5 сая төгрөгийн авлагыг барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн зэрэг дансны бичилтийг хийсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 61,764.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 60,922.8 сая төгрөгөөр баталж, 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 1,204.7 сая төгрөгөөр бууруулан, 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 59,718.1 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 56,708.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,010.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 43,747.6 сая төгрөг, хөрөнгийн санхүүжилтэд 12,422.4 сая төгрөг, нийт 56,170.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тайлант онд 4,377.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, онцгой албан татварын тэмдэгтийн төлбөр 151.5 хувиар биелсэн боловч Татварын шинэчилсэн хуулиар АТБӨЯХ-ийн албан татварын гэрчилгээ, иргэний орлогын цэнхэр дэвтэр, НӨАТ-ын гэрчилгээ хүчингүй болж, цахим хэлбэрт шилжсэнээс туслах үйл ажиллагааны орлого 119.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 8. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	2,890,000.0	4,377,220.6	1,487,220.6	151.5
Туслах үйл ажиллагааны орлого	120,000.0	137.1	(119,862.9)	-
Нийт дүн	3,010,000.0	4,377,357.7	1,367,357.7	145.4

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 56,868.8 сая төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,934.5 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 329.5 сая төгрөг, хөрөнгийн зардал 538.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70205	Татвар хураалт орлого бүрдүүлэлт	59,718,137.7	56,868,794.8	2,849,342.9	95.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	43,196,157.7	40,890,157.0	2,306,000.65	94.7
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	160,736.0	160,736.0	-	100.0
1.3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	130,672.6	128,609.9	2,062.7	98.4
1.4	80219	Харуул, хамгаалалтын зардал	566,080.9	565,705.9	375.0	99.9
1.5	80220	Холбооны суваг ашигласны хөлс	777,679.8	774,926.9	2,752.9	99.6
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,926,310.7	1,926,287.8	22.9	100.0
1.7	80918	Бусад /хөрөнгийн зардал/	12,960,500.0	12,422,371.3	538,128.7	95.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгөөс 963.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 198.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,967.6 сая, нийт 3,129.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 1,961.2 сая, хөрөнгийн зардалд 39.7 сая, нийт 2,000.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,128.4 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд туссан Татвар хураалт, орлого бүрдүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлэх 11 үзүүлэлтийн зорилтот түвшинд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 49,818.9 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр орлого бүрдүүлэлт 46,474.7 сая төгрөг буюу 93.3 хувийн биелэлттэй байна.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд туссан татварын өр барагдуулалт зорилтот түвшиндээ хүрээгүй нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас Засгийн газраас өндөржүүлсэн, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, хилийн хязгаарлалттай холбоотой гадаад худалдаа, барилга, тээврийн салбар, уул уурхайн нүүрсний экспортын хэмжээ буурсан зэргээс шалтгаалан бизнесийн идэвхжил саарч, татвар төлөгчдийн төлбөрийн чадвар буурсан байна.

Мөн УИХ-аас баталсан "Татварын алданги, торгуулиас чөлөөлөх" тухай хуулийг сунгаж, 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд албан татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн албан татвар төлөгчийг нэг удаа чөлөөлсүгэй” гэсэн хуулийн зохицуулалт үйлчилсэн нь татварын өр барагдуулалт хойшлоход нөлөөлжээ.

Татварын ерөнхий газрын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн ангилал зэрэглэлд хамаарах албан тушаалтны ажлын байрны нөхцөлийн талаарх судалгаанаас үзэхэд 1 тэргүүн түшмэл 52 м.кв, 10 эрхэлсэн түшмэл 132.7 м.кв-аар тус тус байвал зохих талбайн хэмжээнээс их талбайтай өрөө ашигладаг байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитын гол асуудалд хөндөх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Татварын албадын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 4,983 мэдээллийг 100 хувь ил тод байршуулснаас 4,791 мэдээлэл буюу 95.7 хувийг нь хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Харьяа байгууллагуудад илэрсэн Нийцлийн аудитын асуудлаар нийт 1,459.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 45.3 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 161.7 сая төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,252.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 12 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Татварын ерөнхий газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон 146.1 сая төгрөгийн төлбөрийн актын биелэлт 100 хувь, шилэн дансны цахим хуудсанд 386 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын нийт 1,451.0 сая төгрөгийн 85 ажил гүйлгээг мэдээлээгүй зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт 95.7 хувь, 382.3 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт.10 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	146,093.6	1	146,093.6			100.0
Албан шаардлага	1	-	1	-			95.7
Зөвлөмж	4	382,300.0	4	382,300.0			90.0
Нийт дүн	6	528,393.6	6	528,393.6			95.2

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолоор төсвийн тухай хуульд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн барилгын ажлын 4,300.6 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэл нь гараагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч, ТЕЗ-ийн барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт, сугалааны хонжворыг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-аас зохион байгуулж явуулдаг боловч татварын буцаан олголт, сугалааны хонжворын урамшууллын санхүүжилтийг Татварын ерөнхий газрын Төрийн сангийн данснаас Төв төрийн сангийн багцын данс руу шилжүүлж байна.

Тайлант онд нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуй нэгжийн орлогын албан татварын буцаалт, сугалааны хонжворын урамшуулалд нийт 207,381.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч хувь хүний нууцтай холбоотой асуудал тул нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн анхан шатны баримт руу тулган баталгаажуулах, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан. Иймд дараагийн тайлант хугацаанд тусгайлсан шалгалт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,144.1 сая төгрөгийн 147 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 5,685.0 сая төгрөгийн 123, нийцлийн аудитын асуудлаар 1,459.1 сая төгрөгийн 24 алдаа зөрчил илрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 5,685.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5,159.5 сая төгрөгийн 48 алдааг аудитын явцад залруулж, 7.2 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 403.9 сая төгрөгийн 28 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 114.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 40 зөвлөмжийг хүргүүллээ.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 525.5 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 740.8 сая төгрөгөөс бага тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 33 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 31 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа Татварын албадын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 31 дүгнэлт өгч, аудитаар нийт 4,687.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 3,228.1 сая төгрөгийн 112, нийцлийн аудитын асуудлаар 1,459.1 сая төгрөгийн 24 алдаа зөрчил илрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 3,228.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,999.4 сая төгрөгийн 45 алдааг аудитын явцад залруулж, 7.2 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 111.3 сая төгрөгийн 23 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 110.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 37 зөвлөмжийг хүргүүллээ.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд тайлант онд зарлага болгосон 22.9 сая төгрөгийн татварын байцаагчийн дүрэмт хувцсыг бараа материалд үлдэгдлээр тайлагнаж, илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 1,012.2 сая, бараа материал 684.7 сая, нийт 1,696.9 сая төгрөгийн орлого, зардлын устгалт хийгээгүйгээс нийт орлого, зардал илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд 440.5 сая төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсөв захирагчид хуваарилсан нэмэлт санхүүжилтийн орлого, зардлын устгалт хийгээгүйгээс нийт орлого, зардал илүү нэгтгэсэн;

4.2.2 Албан шаардлага

1. Том татвар төлөгчийн газар нь Татвар төлөгчдөд зориулсан татварын хууль, эрх зүйн талаар боловсрол олгох сургалтад 5.2 сая төгрөг, Ковидын эсрэг биет тогтсон эсэх шинжилгээ хийлгэхэд 1.3 сая төгрөг, нийт 6.5 сая төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг

гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Том татвар төлөгчийн газар нь тайлант онд бараа материалын тайланг бэлтгэж, тайлагнаагүй, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоог бодож баталгаажуулаагүй, баримтжуулаагүй, мөн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас хоцроож, 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" 14.3.1 анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2 журналд бичих; 14.3.3 дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4 ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5 санхүүгийн тайлан гаргах", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийг иж бүрэн хөтөлж, хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоог бодож баримтжуулан баталгаажуулах, Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

3. Татварын ерөнхий газрын даргын 2021 оны А/122 дугаар тушаалаар тайлант оны үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс 83.3 сая төгрөгийг ахмадын хороо, зөвлөлийн санхүүжилтэд олгосон боловч ахмадын сангийн тайланг баланст нэгтгээгүй, зарцуулалтыг бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 "ахмадын сан" гэж ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын төсөв, үйл ажиллагааны орлогоос хуульд заасан хувь, хэмжээгээр тооцож бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлийн саналыг үндэслэн өөрийн төсөв, жил бүрийн үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулна", 4.1 "Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мэргэжлийн хяналт, аудит, санхүүгийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина", 4.3 "Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, байгууллагын дэргэдэх ахмадын

хороо, зөвлөлд тайлагнана" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Ахмадын сангийн санхүүгийн тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэж, хөрөнгийн зарцуулалтыг бүртгэж, тайлагнаж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

4. Бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зориулж 11.9 сая төгрөг, харуул хамгаалалт, үйлчилгээний ажилчдын нормын хувцас, мод тарих үйл ажиллагаанд ижил хувцсаар жигдрэхэд 14.2 сая төгрөг, Ковидын эсрэг биет тогтсон эсэх шинжилгээ хийлгэхэд 3.8 сая төгрөг, нийт 29.9 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/1877 дугаар албан бичгээр Татварын ерөнхий газрын харьяа Нийслэлийн 5 дүүрэг, 4 аймгийн татварын хэлтсээс нийт 172.8 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг орон нутгийн төсвөөс худалдан бэлтгүүлж, балансаас баланст шилжүүлэн авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6.6.6 "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 25 дугаар зүйлийн 25.2 "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", 25.2.1 "эмнэлгийн үйлчилгээ"; 25.2.2 "бүх шатны боловсролын үйлчилгээ", 25.2.3 "соёлын үйлчилгээ", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр журмын 5 дугаар зүйлийн 5.1 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Харьяа татварын хэлтсүүдээр хөрөнгө бэлтгүүлж, балансаас баланст шилжүүлэн авахгүй байх, төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

4.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 123 дугаар тушаалаар 2021 оны шилдэг ажилтнаа шалгаруулан нэр бүхий 12 ажилтныг шагнахдаа Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан шагналын хэмжээнээс нийт 4.2 сая төгрөгөөр хэтрүүлж, үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.3 “мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг мөрдөж, шагнал урамшууллыг илүү олгохгүй байх;

2. Аудитын үндсэн чиглэлд туссан асуудал

2.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий газрын албадын хэмжээнд автомашинтай холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс 20.0 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс 15.0 сая төгрөгийн өртөгтэй автомашин, Баян-Өлгий аймгийн татварын хэлтэс 6 мотоциклийг харьяа орон нутгийн байгууллагуудын санхүүжилтээр бэлтгэсэн;
- Тайлант онд нийт 60 автомашин бүртгэлтэйгээс 2500 см³ дээш хөдөлгүүрийн багтаамжтай 25 автомашин бүртгэлтэй;
- Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй 35 албан тушаалтан автомашин ашиглаж байна;
- Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Өмнөговь, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Говь-Алтай аймгийн Татвар хэлтсүүд 2, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай аймгийн Татварын хэлтсүүдэд тус бүр 3, Нийслэл, Сонгинохайрхан, Налайх дүүргийн Татварын хэлтсүүд 2-3 автомашин ашиглаж байна.
- Дээрх байдлаас шалтгаалан тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо, даатгал, урсгал засварын зардлууд нэмэгдэж, өмнөх жилүүдээс төсвийн урсгал зардал өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2015 оны 184 дүгэр тогтоолын 2 ба 8 дугаар заалт, хавсралт-ын 2 дахь хэсэг, мөн 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Олон автомашинтай аймаг, нийслэлийн Татварын хэлтсүүдийн автомашиныг цэгцлэх арга хэмжээ авах, албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтнуудын автомашин ашиглаж байгаа асуудлыг таслан зогсоох;

3. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Аудитаар нийт 7,144.1 сая төгрөгийн 147 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 5,685.0 сая төгрөгийн 123, нийцлийн аудитын асуудлаар 1,459.1 сая төгрөгийн 24 алдаа зөрчил илрүүлсэн байна. Тухайлбал:

- Харьяа Татварын албадын санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 3,228.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,999.4 сая төгрөгийн 45 алдааг аудитын явцад залруулж, 7.2 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 111.3 сая төгрөгийн 23 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 110.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 37 зөвлөмжийг хүргүүлсэн нь өмнөх оны аудитын алдаа, зөрчлөөс 2.5 дахин нэмэгдсэн;
- Харьяа Татварын албадын санхүүгийн тайланд залруулсан алдаа өмнөх оноос 1,973.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, тухайлбал: Өмнөговь аймаг 2,030.5 сая төгрөг, Төв аймаг 96.3 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс 47.2 сая төгрөг, Баянгол 459.6 сая төгрөг, Сүхбаатар 61.7 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс 47.9 сая төгрөгийн алдааг тус тус гаргасан нь нягтлан бодогчдын мэдлэг, ур чадвар дутмаг, нэгдсэн арга зүйгээр хангаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.11 "өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж давтан гаргасан алдаа, зөрчлийг арилгах, харьяа Татварын албадын нягтлан бодогчдыг хариуцлагажуулах, нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			Бүгд	зөрчилгүй	хязгаарлалттай	Сөрөг	дүгнэлт өгөхөөс тагалах	Түүвэр	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																				
1	Архангай аймгийн Татварын хэлтэс	АРА-2022/22-НА-СТА-ТШЗ	1	1					1	770.0									1	770.0
2	Баян-Өлгий аймгийн Татварын хэлтэс	БӨА-2022/163/-НА-СТА-ТШЗ	1	1					-	-										
3	Баянхонгор аймгийн Татварын хэлтэс	БНА/2021/178/-НА-СТА-ТШЗ	1	1					1	-									1	
4	Булган аймгийн татварын хэлтэс	БУА-2022/106/-НА-СТА-ТШЗ	1	1					1	1,140.0									1	1,140.0
5	Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс	ГАА-2022/67/НА-СТА-ТШЗ	1	1					5	19,505.1	1	1,902.0	-	-	4	17,603.1	-	-	-	-
6	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	ГСА/2022/23/-СТА-ТШЗ	1	1					2	4,290.9	-	-	-	-	-	-	-	-	2	4,290.9
7	Дархан-Уул аймгийн Татварын хэлтэс	ДАА-2022/127/-НА-СТА-ТШЗ	1	1					4	14,624.9	1	13,448.8	3	1,176.1	-	-	-	-	-	-
8	Дорноговь аймгийн Татварын хэлтэс	ДГА-2022/120/НА-СТА-ТШЗ	1	1					9	58,670.4	3	42,060.0	1	380.0	3	16,230.4	-	-	2	-
9	Дорнод аймгийн Татварын хэлтэс	ДОА-2022/164/НА/СТА-ТШЗ	1	1					2	5,100.0	1	5,100.0	-	-	1	-	-	-	-	-
10	Дундговь аймгийн татварын хэлтэс	ДУА-2021/33/НА-СТА-ТШЗ	1	1					7	32,055.7	3	28,480.9	-	-	4	3,574.8	-	-	-	-
11	Завхан аймгийн Татварын хэлтэс	ЗАА-2022/206/СТА-ТШЗ	1	1					4	13,255.4	4	13,255.4	-	-	-	-	-	-	-	-
12	Орхон аймгийн Татварын хэлтэс	ОРА-2022/20/НА-СТА-ТШЗ	1	1					2	856.9	-	-	-	-	-	-	-	-	2	856.9
13	Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс	ӨВА-2022/131/НА-СТА-ТШЗ	1	1					2	696.0	1	250.0	-	-	1	446.0	-	-	-	-
14	Өмнөговь аймгийн Татварын хэлтэс	ӨМА-2022/113/НА-СТА-ТШЗ	1	1					7	2,031,315.4	5	2,030,501.0	-	-	2	814.3	-	-	-	-
15	Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс	СБА-2022/17/НА-СТА-ТШЗ	1	1					3	8,734.7	1	43.0	-	-	1	8,691.7	-	-	1	-
16	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс	СЭА-2022/224/НА-СТА-ТШЗ	1	1					2	36,537.4	-	-	-	-	-	-	-	-	2	36,537.4

Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

17	Төв аймгийн Татварын хэлтэс	ТӨА-2022/18/НА-СТА-ТШЗ	1	1					7	128,934.9	2	96,293.7	1	256.2	3	32,385.0	-	-	1	-
18	Увс аймгийн Татварын хэлтэс	УВА-2022/50/НА-СТА-ТШЗ	1	1					1	7,067.2	1	7,067.2								
19	Ховд аймгийн Татварын хэлтэс	ХОА-2022/30/НА-СТА-ТШЗ	1	1					4	10,738.9	2	7,770.0	-	-	-	-	-	-	2	2,968.9
20	Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс	ХӨА-2022/245/НА-СТА-ТШЗ	1	1					3	25,300.0	1	20,500.0	-	-	-	-	-	-	2	4,800.0
21	Хэнтий аймгийн Татварын хэлтэс	ХЭА-2022/14/НА-СТА-ТШЗ	1	1					-	-										
22	Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/304/НА-СА-ТШЗ	1	1					5	12,457.4	1	4,038.7	-	-	-	-	-	-	4	8,418.7
23	Багахангай дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/80/НА-СА-ТШЗ	1	1					5	10,107.6	3	8,827.6	-	-	-	-	-	-	2	1,280.0
24	Налайх дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/372/НА-СТА- ТШЗ	1	1					6	19,150.9	2	10,296.4	1	1,389.3	2	7,272.5	-	-	1	192.7
25	Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс	НТАГ-2022/81/НА-СТА-ТШЗ	1	1					2	65,194.9	1	61,660.9	-	-	-	-	-	-	1	3,534.0
26	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/675/НА-СА-ТШЗ	1	1					3	62,398.8	1	47,977.8	-	-	-	-	-	-	2	14,421.0
27	Нийслэлийн татварын газар	НТАГ-2022/697/НА-СА-ТШЗ	1	1					3	43,761.9	1	40,982.3	-	-	-	-	-	-	2	2,779.6
28	Багануур дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/83/НА-СТА-ТШЗ	1	1					9	50,703.8	4	41,842.5	1	4,000.0	1	130.7	-	-	3	4,730.6
29	Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/79/НА-СА-ТШЗ	1	1					4	41,582.6	2	35,642.3	-	-	-	-	-	-	2	5,940.3
30	Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/174/НА-СА-ТШЗ	1	1					4	39,359.1	1	21,825.8	-	-	-	-	-	-	3	17,533.3
31	Баянгол дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/82/НА-СА-ТШЗ	1	1					4	483,784.0	3	459,624.4	-	-	1	24,159.6	-	-	-	-
32	Татварын ерөнхий газар	АХГ-2022/11/НА-СТА-ТТЗ	2					2	11	2,456,909.1	3	2,160,133.4	-	-	5	292,559.5	-	-	3	4,216.2
Нийт дүн			33	31	0	0	0	2	123	5,685,003.9	48	5,159,524.1	7	7,201.6	28	403,867.6	-	-	40	114,410.5

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Нийцлийн аудитын асуудлаар														
1	Архангай аймгийн Татварын хэлтэс	АРА-2022/22-НА-СТА-ТШЗ	-	-										
2	Баян-Өлгий аймгийнТатварын хэлтэс	БӨА-2022/163/-НА-СТА-ТШЗ	-	-										
3	Баянхонгор аймгийн Татварын хэлтэс	БНА/2021/178/-НА-СТА-ТШЗ	1	17,164.9									1	17,164.9
4	Булган аймгийн татварын хэлтэс	БУА-2022/106/-НА-СТА-ТШЗ	-	-										
5	Говь-Алтай аймгийн Татварын хэлтэс	ГАА-2022/67/НА-СТА-ТШЗ	2	45,273.0	1	45,273.0	-	-	-	-	-	-	1	-
6	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	ГСА/2022/23/-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул аймгийн Татварын хэлтэс	ДАА-2022/127/-НА-СТА-ТШЗ	1	128,855.4	-	-	-	-	-	-	-	-	1	128,855.4
8	Дорноговь аймгийн Татварын хэлтэс	ДГА-2022/120/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9	Дорнод аймгийн Татварын хэлтэс	ДОА-2022/164/НА/СТА-ТШЗ	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
10	Дундговь аймгийн татварын хэлтэс	ДУА-2021/33/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Завхан аймгийн Татварын хэлтэс	ЗАА-2022/206/СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	Орхон аймгийн Татварын хэлтэс	ОРА-2022/20/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
13	Өвөрхангай аймгийн Татварын хэлтэс	ӨВА-2022/131/НА-СТА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
14	Өмнөговь аймгийн Татварын хэлтэс	ӨМА-2022/113/НА-СТА-ТШЗ	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
15	Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс	СБА-2022/17/НА-СТА-ТШЗ	1	654,787.9	-	-	-	-	-	-	-	-	1	654,787.9
16	Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс	СЭА-2022/224/НА-СТА-ТШЗ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
17	Төв аймгийн Татварын хэлтэс	ТӨА-2022/18/НА-СТА-ТШЗ	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
18	Увс аймгийн Татварын хэлтэс	УВА-2022/50/НА-СТА-ТШЗ	-	-										
19	Ховд аймгийн Татварын хэлтэс	ХОА-2022/30/НА-СТА-ТШЗ	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
20	Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс	ХӨА-2022/245/НА-СТА-ТШЗ	1	3,800.0	-	-	-	-	-	-	-	-	1	3,800.0
21	Хэнтий аймгийн Татварын хэлтэс	ХЭА-2022/14/НА-СТА-ТШЗ	-	-										

Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

22	Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/304/НА-СА-ТШЗ	1	8,677.6	-	-	-	-	1	8,677.6	-	-	-	-
23	Багахангай дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/80/НА-СА-ТШЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
24	Налайх дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/372/НА-СТА-ТШЗ	2	113,520.9	-	-	-	-	2	113,520.9	-	-	-	-
25	Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс	НТАГ-2022/81/НА-СТА-ТШЗ	2	141,335.1	-	-	-	-	1	5,851.5	-	-	1	135,483.6
26	Чингэлтэй дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/675/НА-СА-ТШЗ	2	94,935.3	-	-	-	-	1	5,639.3	-	-	1	89,296.0
27	Нийслэлийн татварын газар	НТАГ-2022/697/НА-СА-ТШЗ	1	29,628.0	-	-	-	-	-	-	-	-	1	29,628.0
28	Багануур дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/83/НА-СТА-ТШЗ	1	608.2	-	-	-	-	1	608.2	-	-	-	-
29	Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/79/НА-СА-ТШЗ	2	204,933.4	-	-	-	-	1	11,832.0	-	-	1	193,101.4
30	Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/174/НА-СА-ТШЗ	1	8,643.1	-	-	-	-	1	8,643.1	-	-	-	-
31	Баянгол дүүргийн Татварын хэлтэс	НТАГ-2022/82/НА-СА-ТШЗ	1	6,916.0	-	-	-	-	1	6,916.0	-	-	-	-
32	Татварын ерөнхий газар	АХГ-2022/11/НА-СТА-ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн			24	1,459,078.8	2	45,273.0	-	-	10	161,688.6	-	-	12	1,252,117.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 660/А0160061
АХТ-2022/11/НА-СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/1877 дугаар албан бичгээр Татварын ерөнхий газрын харьяа Нийслэлийн 5 дүүрэг, 4 аймгийн татварын хэлтсээс нийт 172,812,800.00 төгрөгийн тавилга, эд хогшлыг орон нутгийн төсвөөс худалдан бэлтгүүлж, балансаас баланст шилжүүлэн авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6.6.6 "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 25 дугаар зүйлийн 25.2 "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", 25.2.1 "эмнэлгийн үйлчилгээ", 25.2.2 "бүх шатны боловсролын үйлчилгээ", 25.2.3 "соёлын үйлчилгээ", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр журмын 5 дугаар зүйлийн 5.1 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа Татварын хэлтсүүдээр хөрөнгө бэлтгүүлж, балансаас баланст шилжүүлэн авахгүй байх, төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбадорж, Ерөнхий нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

П.ЧАНЦАЛДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 661/А0160061

Улаанбаатар хот

АХП-2022/11/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын ерөнхий газрын даргын 2021 оны А/122 дугаар тушаалаар тайлант оны үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс 83,300,000.00 төгрөгийг ахмадын хороо, зөвлөлийн санхүүжилтэд олгосон боловч ахмадын сангийн тайланг баланст нэгтгээгүй, зарцуулалтыг бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37 "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 "ахмадын сан" гэж ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын төсөв, үйл ажиллагааны орлогоос хуульд заасан хувь, хэмжээгээр тооцож бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.2 "Аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлийн саналыг үндэслэн өөрийн төсөв, жил бүрийн үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулна", 4.1 "Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мэргэжлийн хяналт, аудит, санхүүгийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина", 4.3. "Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлд тайлагнана" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ахмадын сангийн санхүүгийн тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэж, хөрөнгийн зарцуулалтыг бүртгэж, тайлагнаж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-289.Docx

0001021585

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбадорж, Ерөнхий нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

П.ЧАНЦАЛДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 01 дугаар сарын 25 № 663/А0160061

Улаанбаатар хот

АХТ-2022/11/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Том татвар төлөгчийн газар нь тайлант онд бараа, материалын тайланг бэлтгэж, тайлагнаагүй, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоог бодож баталгаажуулаагүй, баримтжуулаагүй, мөн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас хоцроож, 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/97 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ" 14.3.1 анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2 журналд бичих; 14.3.3 дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4 ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5 санхүүгийн тайлан гаргах", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг иж бүрэн хөтөлж, хөрөнгийн тооллогын бүртгэл, тооцоог бодож баримтжуулан баталгаажуулах, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, нягтлан бодогч Б.Уранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР  П.ЧАНЦАЛДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

МОНГОЛ
УЛСЫН АУДИТОР

Z:\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-288.Docx

0001001583



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 664/A01600061

Улаанбаатар хот

АХП - 2022/11/НА - СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зориулж 11,890,000.00 төгрөг, харуул хамгаалалт, үйлчилгээний ажилчдын нормын хувцас, мод тарих үйл ажиллагаанд ижил хувцсаар жигдрэхэд 14,223,000.00 төгрөг, ковидын эсрэг биет тогтсон эсэх шинжилгээ хийлгэхэд 3,800,000.00 төгрөг, нийт 29,913,000.00 төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбадорж, Ерөнхий нягтлан бодогч Б.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР  П.ЧАНЦАЛДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

110-10-10-20210115_KheregiAlban-Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-290.Docx

0001081589



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 665

Улаанбаатар хот

АХГ- 2022/11/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Татварын ерөнхий газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Том татвар төлөгчийн газар нь Татвар төлөгчдөд зориулсан татварын хууль, эрх зүйн талаар боловсрол олгох сургалтад 5,205,750.00 төгрөг, ковидын эсрэг биет тогтсон эсэх шинжилгээ хийлгэхэд 1,328,000.00 төгрөг, нийт 6,533,750.00 төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна. 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт- шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, нягтлан бодогч Б.Уранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР

П.ЧАНЦАЛДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109 9019120386 \\10.10.10.20\Bichle_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-287.Docx

0001091581

[illegible]